LION AUDIT

Address: Kyokushu Tower, # 1204
6th khoroo, Bayangol District,
Ulaanbaatar-16081, Mongolia

Phone: +976-70126778
Fax: +976-70126778
E-mail: delgertsetseg@cpa.mn

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## “ХӨВСГӨЛ УСАН ЗАМ” ХК -ИЙН ЗАХИРАЛ ТАНАА

Бид 2017 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, мөн өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол гол бодлогууд ба бусад нэмэлт тайлбар мэдээллүүдийг багтаасан **“ХӨВСГӨЛ УСАН ЗАМ” ХК** ийн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

### Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хариуцлага

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан эсвэл алдааны улмаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтын үүрэг хариуцлага мөн багтдаг.

### Аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол эдгээр санхүүгийн тайлангуудад аудитын дүгнэлт өгөх явдал юм. Бид өөрсдийн аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаанаас ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн тоон үзүүлэлтүүд ба тодруулгуудын талаар аудитын нотолгоог олж авахын тулд аудитын горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгосон горимууд нь аудитор залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг төлөвлөхийн тулд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг.
Түүнчлэн аудитын ажилд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудын үндэслэлтэй байдал болон санхүүгийн тайлангийн толилуулгыг ерөнхийд нь үнэлж үзэх ажлууд багтдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоонууд нь аудитын дүгнэлт өгөхөд хангалттай ба зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэж байна.

Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангууд 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх “ХӨВСГӨЛ УСАН ЗАМ” ХК-ийн санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

ЗАХИРАЛ Г.ДЭЛГЭРЦЭЦЭГ

2018 ОНЫ 02 ДУГААР САРЫН 05

МОНГОЛ УЛС

УЛААНБААТАР ХОТ

"ХӨВСГӨЛ УСАН ЗАМ" ХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2017 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

| | Тодруулга | 2017.12.31 | 2016.12.31 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 27,912 | 897,243 |
| Дансны авлага | | | 1,086,852 |
| Татвар, НДШ-ийн авлага | 5 | 313,416 | 581,198 |
| Бараа материал | 6 | 2,421,461 | 4,901,011 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 7 | 7,021,825 | 9,242,100 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **9,784,613** | **16,708,404** |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Үндсэн хөрөнгө | 8 | 104,583,634 | 106,237,964 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | | 1 | |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **104,583,635** | **106,237,964** |
| **Нийт хөрөнгийн дүн** | | **114,368,248** | **122,946,368** |
| **Өр ба эзний өмч** | | | |
| Дансны өглөг | | 95,008,601 | 116,888 |
| Банкны богино хугацаатай зээл | | 3,418,323,758 | 2,576,289,401 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | | | 35,200 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **3,513,332,360** | **2,576,441,489** |
| **Урт хугацаат өр** | | | |
| Урт хугацаат зээл | | | |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **-** | **-** |
| **Нийт өр төлбөрийн дүн** | | **3,513,332,360** | **2,576,441,489** |
| **Эздийн өмч** | | | |
| Өмч | 1 | 9 442,600 | 98,000,000 |
| Хуримтлагдсан ашиг | | (3,408,406,712) | (2,551,495,121) |
| **Эздийн өмчийн дүн** | | **(3,398,964,112)** | **(2,453,495,121)** |
| **Нийт өр ба эзний өмчийн дүн** | | **114,368,248** | **122,946,368** |

Lionaudit LLC

"ХӨВСГӨЛ УСАН ЗАМ" ХК

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2017 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР

ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

| | Тодруулга | 2017.12.31 | 2016.12.31 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого (цэвэр) | | 275,335,906 | 233,784,269 |
| Борлуулалтын өртөг | | | |
| **Нийт ашиг (алдагдал)** | | **275,335,906** | **233,784,269** |
| Хүүний орлого | | 7,912 | 5,918 |
| Бусад орлого | | 1 | 1,208,824 |
| Борлуулалт маркетингийн зардал | | (7,716,866) | (3,235,961) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | | (202,342,934) | (159,408,320) |
| Санхүүгийн зардал | | (928,206,721) | (525,980,116) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз, (гарз) | | 7,252,176 | (311,434,870) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, (гарз) | | (696,797) | |
| Бусад ашиг (алдагдал) | | (544,268) | (4) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | | **(856,911,591)** | **(765,060,259)** |
| Татварын зардал | | | |
| **Татвар төлсөний дараах ашиг** | | **(856,911,591)** | **(765,060,259)** |

Lionaudit LLC

**"ХӨВСГӨЛ УСАН ЗАМ" ХК**
**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
**2017 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР**
**ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ**

| | Хувьцаа | Хуримтлагдсан ашиг | Бүгд |
|---|---|---|---|
| **2016 оны 12 сарын 31 ны өдөр** | **98,000,000** | **(2,551,495,121)** | **(2,453,495,121)** |
| Тайлан үеийн цэвэр ашиг алдагдал | | (856,911,591) | (856,911,591) |
| Өмчид гарсан өөрчлөлт | (88,557,400) | | (88,557,400) |
| **2017 оны 12 сарын 31 ны өдөр** | **9,442,600** | **(3,408,406,712)** | **(3,398,964,112)** |

"ХӨВСГӨЛ УСАН ЗАМ" ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2017 ОНЫ 12 САРЫН 31 НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР
ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛЭВ

| | 2017.12.31 | 2016.12.31 |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 294,519,428 | 277,377,490 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 3,071,000 | |
| Бусад мөнгөн гүйлгээ | 200,000 | 304,000 |
| Ажиллагчдад олгосон мөнгө | (58,949,279) | (46,173,112) |
| Нийгмийн даатгалын байгууллагдад төлсөн мөнгө | (13,060,200) | (9,570,000) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | (14,238,733) | (22,304,337) |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | (4,811,598) | (7,608,787) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөн | (39,443,773) | (67,964,357) |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө | (22,292,137) | (32,400,392) |
| Хүүний төлбөрт төлсөн | (130,000,000) | (31,700,200) |
| Татварын байгууллагад төлсөн | (41,242,013) | (48,832,404) |
| Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | (12,694,060) | (14,060,200) |
| Бусад мөнгөн зарлага | | (3,872,050) |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(38,941,366)** | **(6,804,349)** |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | (13,627,635) | (3,769,970) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(13,627,635)** | **(3,769,970)** |
| **Санхүүгийн үйл ажиллагаа** | | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 51,699,669 | 66,000,000 |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | | (55,541,800) |
| Валютын ханшийн зөрүү | | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **51,699,669** | **10,458,200** |
| **Мөнгөн хөрөнгийн өсөлт бууралт** | **(869,332)** | **(116,119)** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **897,243** | **1,013,362** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **27,912** | **897,243** |

Tonaudit LLC